

2013 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ХЭЛХЭЭС

01.21-22

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Бронислав Коморовскийн урилгаар БНПУ-д Төрийн айлчлал хийв.

01.31

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга У Бангуог хүлээн авч уулзлаа

02.15-16.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Өмнөд Судандахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа өөрийн цэргийн батальоны ажиллагаатай танилцахаар Өмнөд Суданд айлчиллаа.

02.28

НҮБ-ын Соёл, иргэншлийн холбооны 5 дугаар чуулга уулзалтанд Монгол Улсын Гадаад харилцааны сайд Л.Болд тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо.

03.13

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Европын Холбооны Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын ассамблейн ерөнхийлөгч Рикардо Мильори тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

03.25

Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Куба Улсын Засгийн Газар хоорондын өр чөлөөлөх тухай хэлэлцээр байгуулагдлаа.

03.30

Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ Монгол Улсад айлчиллаа. Айлчиллын үеэр Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэ тус улс Монгол Улстай стратегийн түншлэлээ гүнзгийрүүлэх хүсэлтэй байгааг илэрхийлэв.

04.16-17

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Л.Болд Кувейт Улсад албан ёсны айлчлал хийв.

04.27-29

Монгол Улсад Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн

Сайд нарын VII бага хурлыг зохион байгууллаа. Монгол Улс Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг 2011 оны долдугаар сараас эхлэн даргалж байгаа тул ийнхүү Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын VII бага хурлыг эх орондоо зохион байгуулж байгаа юм.

04.29

Монгол Улсын Ерөнхийлөгчид Йемений Нобелийн шагналт Т.Карман, Нигери улсын дэд Ерөнхийлөгч Мохаммед Намади Самбо нар бараалхав.

04.29

Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Польш Улсын Гадаад хэргийн яамд хоорондын ээлжит Зөвлөлдөх уулзалт энэ сарын 29-ний өдөр Варшав хотноо боллоо.

06.05

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Ногоон эдийн засгийн төлөөх үйл ажиллагааны түншлэл” хэмээх шинэ хөтөлбөрт манай улс багтсаныг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс албан ёсоор зарлалаа.

06.9-12

Гадаад харилцааны сайд Л.Болд Япон Улсад ажлын айлчлал хийж, “Дэлхийн эдийн засгийн форумын Япон дахь уулзалт-2013” арга хэмжээнд оролцов.

06.19

Монгол Улс Антигуа Барбуда Улстай Нью-Йорк хотноо дипломат харилцаа тогтоов.

06.24

Монгол Улс Эритри Улстай Нью-Йорк хотноо дипломат харилцаа тогтоов.

07.01-02

Гадаад харилцааны сайд Л.Болд тэргүүтэй төлөөлөгчид Бруней Улсын нийслэл Бандар Сери Бегаван хотноо болсон 1994 онд үйл ажиллагаагаа эхэлсэн, эгнээндээ 27 улс орныг нэгтгэсэн АСЕАН-ы Бүсийн чуулга (АРФ)-ын Сайд нарын 20 дугаар уулзалтад оролцлоо.

07.08

Монгол Улс Бурунди Улстай Нью-Йорк хотноо дипломат харилцаа тогтоов.

07.09

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид Японы Үндэсний аюулгүй байдал, хулгайлагдсан иргэд, гамшгийн асуудал эрхэлсэн

сайд К.Фүрүя тэргүүтэй төлөөлөгчид бараалхав. Уулзалтын үеэр олон улс, бүс нутгийн хамтын ажиллагааны талаар зарим асуудлаар санал солилцов.

07.09

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дэд дарга Сянба Пинцуо тэргүүтэй төлөөлөгчид бараалхав.

07.31

Гадаад харилцааны сайд Л.Болд Монголын Зүүн Хойд Нийгэмлэгийн урилгаар Монгол Улсад ажлын айлчлал хийж байгаа Японы Олон улсын найрамдал, солилцооны зөвлөл /International Foreign Exchange Council/-ийн Н.Ито тэргүүтэй төлөөлөгчдийг ГХЯ-нд хүлээн авч уулзлаа.

08.08-09

Монгол Улс, БНХАУ-ын ГХЯ-дын консулын XV зөвлөлдөх уулзалт Улаанбаатар хотноо болж өнгөрлөө.

08.14

Гадаад харилцааны сайд Л.Болд Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/-ын Ерөнхий захирал, хатагтай Др.Маргаретыг хүлээн авч уулзлаа.

08.20

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Л.Болдын урилгаар Шинэ Зеландын Гадаад хэргийн сайд Маррей Маккали энэ сарын 20-нд манай улсад албан ёсны айлчлал хийлээ.

08.26-27

Монгол, Чехийн Засгийн газар хоорондын хамтарсан комиссын ээлжит тавдугаар хуралдаан энэ сарын 26-27-ны өдрүүдэд Прага хотноо болов.

09.02

Хамтын ажиллагааны Монгол, Францын Засгийн газар хоорондын ажлын хэсгийн анхдугаар хуралдаан энэ сарын 2-нд БНФУ-ын нийслэл Парис хотноо амжилттай боллоо.

09.04

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийн урилгаар Бүгд Найрамдах Беларусь улсын Ерөнхий сайд эрхэмсэг ноён Михаил Владимирович Мясникович манай улсад албан ёсны айлчлал хийв. Хоёр орны Ерөнхий сайд нар ганцаарчилсан уулзалт болон өргөтгөсөн хэлэлцээ хийлээ.

09.06

Монгол Улс Бүгд Найрамдах Того Улстай Нью-Йорк хотноо

дипломат харилцаа тогтоов.

09.10

Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны Хамтарсан хорооны ээлжит XV хуралдаан Улаанбаатар хотноо болов.

09.11-14

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Япон Улсын Засгийн газрын урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийж, Японы Эзэн хаан Акихитод бараалхаж, Ерөнхий сайд Ш.Абэ-тай албан ёсны хэлэлцээ хийлээ.

09.12

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/-ын дээд хэмжээний 13 дахь удаагийн уулзалт Киргиз улсын нийслэл Бишкек хотноо зохион байгуулагдаж, уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж оролцлоо.

09.26

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж НҮБ-ын ерөнхий ассамблейн 68 дугаар чуулганд оролцлоо.

09.27

Монгол Улс Бүгд Найрамдах Суринам Улстай Нью-Йорк хотноо дипломат харилцаа тогтоов.

09.27

Монгол Улс Бүгд Найрамдах Сьерра Леон Улстай Нью-Йорк хотноо дипломат харилцаа тогтоов.

10.04-05

Индонезийн Балид зохиогдсон Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-ын Гадаад хэргийн сайд нарын уулзалтад Монгол Улсын Гадаад харилцааны сайд Л.Болд АПЕК-ын дарга орон-Индонезийн Засгийн газрын урилгаар тусгай зочноор оролцлоо.

10.20

УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Л.Болд Москва хотноо болсон Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад оролцлоо.

10.21

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн урилгаар Бүгд найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Бронислав Коморовски Монгол Улсад айлчиллаа.

10.22-26

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көцяны урилгаар БНХАУ-

д албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд Монгол Улс, Бүгд найрамдах Хятад ард Улсын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр баталлаа.

10.25

Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар төрийн айлчлал хийж байгаа Канад улсын Амбан захирагч Дэвид Жонстоны айлчлалын хүрээнд Монгол, Канадын талууд нэг баримт бичиг солилцож, хоёр баримт бичигт гарын үсэг зуран, албан ёсны хэлэлцээ хийв.

10.28-31

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад төрийн айлчлал хийлээ. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж, БНАСАУ-ын Ардын дээд Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ким Ён Нам нар албан ёсны хэлэлцээ хийлээ.

11.05

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага ЮНЕСКО-гийн 37 дугаар Ерөнхий бага хурал Парис хотноо боллоо. Энэ удаагийн бага хуралд манай улсаас Гадаад харилцааны сайд, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын дарга Л.Болд тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо.

11.8-9

Гадаад харилцааны сайд Л.Болд Бүгд Найрамдах Серби Улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын эхний өдөр сайд Л.Болд тус улсын Ерөнхий сайд И.Дачич-д бараалхаж Гадаад харилцааны сайд И.Маркичтэй албан ёсны хэлэлцээ хийв.

11.17

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Европын комиссын Ерөнхийлөгч Жозе Мануэл Баррозо Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ.

11.18-21

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад /МХБНУ/ төрийн айлчлал хийлээ.

11.20

Монгол Улс Бүгд Найрамдах Уганда Улстай 11 дүгээр сарын 20-ны өдөр Нью-Йорк хотноо дипломат харилцаа тогтоов. Хоёр улс найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх хоёр талын эрмэлзлийг удирдлага болгож, Дипломат харилцааны тухай Венийн конвенц, НҮБ-ын Дүрэм, олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээг баримтлахаа тохиролцов.

11.21

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад /БНСВУ/ айлчилж, Хоёр орны Ерөнхийлөгчид албан ёсны хэлэлцээ хийлээ.

11.25

Бүгд Найрамдах Руанда Улстай Нью-Йорк хотноо дипломат харилцаа тогтоов. Хоёр улс найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх хоёр талын эрмэлзлийг удирдлага болгож, Дипломат харилцааны тухай Венийн конвенц, НҮБ-ын Дүрэм, олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээг баримтлахаа тохиролцов.

11.25

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Бүгд Найрамдах Сингапур Улсын /БНСУ/ Ерөнхийлөгч Тони Тан Денг Яамын урилгаар Сингапур улсад албан ёсны айлчлал хийлээ.

11.28

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж "The Economist" сэтгүүлээс БНХАУ-ын ЗЗОБ Хонконгд зохион байгуулсан "Дэлхий 2014 онд" олон улсын эдийн засгийн арга хэмжээнд оролцлоо.

12.03-06

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын Сайд нарын 9 дүгээр бага хурал Индонезийн Балид энэ оны 12 дугаар сарын 3-наас 6-ны өдрүүдэд хуралдлаа.

12.06

Монгол Улс Бүгд Найрамдах Холбооны Микронез Улстай Бээжин хотноо энэ сарын 6-нд дипломат харилцаа тогтоов.

12.11-12

Монгол, Хятадын хилийн хамтарсан комиссын анхдугаар хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Бээжин хотноо болов.

12.16-19

Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва 2013 оны 12 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд ХБНГУ-д ажлын айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд Шадар сайд 12 дугаар сарын 17-ны өдөр болсон ХБНГУ-ын Бундестаг Холбооны Канцлерыг сонгох болон Холбооны Канцлер Ангела Меркелийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд оролцов.